

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр, Даваа гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-8</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>1-3</i>

<i>1. Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулга болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нарын 6 гишүүн 2023.03.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	<i>4-8</i>
--	------------

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ж.Батжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 51 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Томилолттой: Б.Саранчимэг, Г.Ганболд, Н.Ганибал, Г.Тэмүүлэн, Ц.Туваан;
Чөлөөтэй: Ц.Анандбазар, Г.Мөнхцэцэг, Д.Өнөрболор, О.Цогтгэрэл.*

Нэг.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулга болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нарын 6 гишүүн 2023.03.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Органик хүнс, хүнсний сав, баглаа боодлын асуудал хариуцсан хэлтсийн ахлах шинжээч Д.Тунгалаг, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Монгол Улсын Их сургуулийн Бизнесийн сургуулийн профессор Н.Отгонсайхан, Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн мэргэжилтэн Б.Алтанцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Х.Болорчулуун нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.

Ж.Батжаргал: Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төслийн талаар болон хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс бэлтгэсэн дараах 3 зарчмын зөрүүтэй саналаар дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

1.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төслийн талаар:

Ж.Батжаргал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.3.Гаалийн байгууллага улсын хилээр нэвтрүүлсэн органик бүтээгдэхүүнтэй холбоотой мэдээллийг мэдээллийн санд илгээнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтын “дотоодод үйлдвэрлэсэн” гэсний дараа “, баталгаажсан, мэдээллийн санд бүртгэлтэй” гэж нэмж, мөн заалтын “ашиглаж байгаа тариалангийн анхан шатны” гэснийг “ашигласан тохиолдолд” гэж өөрчилж, мөн зүйлийн 15.1.2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Ж.Батжаргал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.5.10¹.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 4.1.2-т заасан органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн аж ахуйн нэгжийн зөвхөн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсэн эхний 5 жилд 90 хувиар, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 90 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 18 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 16 цаг 09 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим, 15 цаг 51 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Батжаргал: Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Улсын Их Хурлын гишүүн Аубакир, Бат-Эрдэнэ, Бейсен, Дамдинням, Идэрбат, Наранбаатар, Цэрэнпунцаг, Энхтүвшин, Болорчулуун, Батжаргал нар хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52.6 хувьтай байгаа тул Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааныг нээж байна.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэнэ.

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нарын 6 гишүүн 2023 оны 3 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлэг. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу. Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн мэдээллийг Байнгын хорооны гишүүдэд хүргүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Баттөмөр танилцуулна. Баттөмөр гишүүний микрофоныг өгье.

Б.Баттөмөр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Органик бүтээгдэхүүний тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг 2024 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Ажлын хэсгээс Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь заалтын дагуу нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт дахин санал хураалгах шаардлагатай гэж 3 зарчмын зөрүүтэй саналыг боловсруулан та бүхэнд танилцуулж байна.

Нэгдүгээрт, чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллын 16 дахь саналд гаалийн байгууллагад органик бүтээгдэхүүнтэй холбоотой мэдээллийг мэдээллийн санд оруулах үүрэгтэй гэж байсныг мэдээллийн санд илгээх үүрэгтэй байхаар,

Мөн зарчмын зөрүүтэй саналын томъёоллын 21 дэх саналын ашиглах тохиолдол гэснийг ашигласан тохиолдолд гэж өөрчиллөө.

Хоёрдугаарт нь, Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дэх заалтын органик бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн аж ахуйн нэгжийн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох албан татварыг 90 хувиар хөнгөлнө гэснийг орлого олж эхэлсэн эхний 3 жилд 90 хувиар, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө гэсэн агуулгаар өөрчилсөн.

Та бүхэнд органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцүүлгийг дэмжигдсэн саналын төсөлд нэмж тусгасан хуулиар болон чуулганы нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт хураалгах зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,
Органик бүтээгдэхүүний хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх ажлын хэсгээс гаргасан зармын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Батжаргал: Баттөмөр гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Мэндбаярын Дондогдорж, тус яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Даваагийн Тунгалаг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Органик хүнс, хүнсний сав баглаа боодлын асуудал хариуцсан хэлтсийн ахлах шинжээч, Нямдаваагийн Отгонсайхан Монгол Улсын Их сургуулийн Бизнесийн сургуулийн доктор, профессор, Балганы Алтанцэцэг НҮБ-н Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн мэргэжилтэн гэсэн ийм бүрэлдэхүүн хүрэлцэн ирсэн байна.

Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу. Байхгүй. Бат-Эрдэнэ гишүүнээр тасалъя. Болорчулуун гишүүн. Болорчулуун гишүүний микрофоныг өгье.

Х.Болорчулуун: Баярлалаа. Органик бүтээгдэхүүний тухай хууль орж байна. Энэ дээр бас нэг зарчмын 3 саналыг дахиж Байнгын хороо хэлэлцэх ийм шийдэл, чиглэл өгсөн байна. Энэ дээр ялангуяа тэр 3 дахь нь буюу татвартай холбоотой асуудал. Ер нь органик бүтээгдэхүүн гэдэг бол өөрөө маш өндөр зардлаар гардаг ийм нэлэнхий их масс хэмжээгээр биш аливаа улс оронд бий болдог. Нэн ялангуяа Монгол Улсын хувьд бол өргөн уудам газар нутагтай, бага хүн амтай болохоор органик бүтээгдэхүүн хэрэглэх тал руу бол төрийн урамшуулал дэмжлэг, хөшүүрэг бол бас сайн байх ёстой. Энэ бол хуулиар дамжиж, хэрэгжүүлэх нь ойлгомжтой. Тэгэхээр тэр органик бүтээгдэхүүн бий болгож, худалдан борлуулбал татварын 90 хувиар татвараас хөнгөлнө гэж байсан. Энийг бол бид дэмжиж байсан. Энийг хэрэв дэмжих боломжгүй гэж байгаа бол эхний 3 жил 100 хувь, дараагийн 3 жил 50 хувь хөнгөлнө гэдэг чинь бол бага л даа. Ядахдаа эхний 5 жил 100 хувь, дараагийн 5 жил 50 хувь гээд 10 жилийг ийм хөнгөлөлттэй байхгүй бол энэ бол дэмжлэг, хөшүүрэг биш болно шүү. Уг нь ингэж органик бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хөшүүрэг, урамшуулал сайн хэрэглэвэл энэ тал руу үйлдвэрлэгч нар чиглэсэн бодлого их явах юм гэдгийг л хэлэх байна.

Ж.Батжаргал: Дэгээр Баттөмөр гишүүн хариулт өгч болно тийм үү. Хариулт өгье.

Б.Баттөмөр: Эхний 2 санал бол найруулгын шинж чанартай санал юм байгаа юм. Гаальд илгээнэ. Гааль шалгана гэж байсныг Гааль бол илгээнэ. Өөрөөр хэлбэл Хүнс, хөдөө аж ахуйн яам руу илгээнэ. 2 дахь саналын хувьд бол ашигласан тохиолдол гэж байсныг нь тэгж найруулсан юм. Сайдын санал бол уг нь зөв л дөө. Ер нь аливаа юм хэмжээ хязгаартай байх нь дээр юм. Бид чинь ингээд байж байх учраас 90 хувиар хугацааг нь заахгүйгээр гэдэг нь болохгүй байна гээд манай ажлын хэсгийн гишүүд,

ялангуяа ажлын дэд хэсгээс гарсан санал. Тэгээд бид нар ярьж байгаад ер нь энийг хугацаатай. Анх орж ирэхдээ бол 90 хувь л гэж орж ирсэн. Тэгээд сайд бол 100 хувь гэж байна. Энэ чинь 90 хувь гэж орж ирсэн учраас 90 хувийн хэмжээнд л гэж яриад байгаа юм. Тэгээд ажлын дэд хэсэг бол эхний 3 жилд 90 хувиараа явъя. Тэгээд цаашаа явцыг нь харж байгаад зохицуулъя гэсэн ийм санал олонхын саналыг авсан. Тэгээд оруулж ирж байгаа юм л даа. Тэгээд түрүүн бол 90 хувиараа ороод явсан байгаа. Хэрвээ энэ санал 3/2-оор босно шүү дээ. Ийм л байдалтай байгаа юм.

Ж.Батжаргал: Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Юуны өмнө Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд бид нар өөрчлөлт оруулаад малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотой гэх мэтчилэн яам дээр хяналтын институц, мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсантай холбоотой бүх хяналтын байгууллагыг эрх үүрэг нь бол яам дээр шилжсэн шүү дээ. Тэр дээр энэ органик бүтээгдэхүүнтэй холбоотой асуудлууд нь хаягдчихаад байсан юм. Тэгэхээр энэ хуулиар энэ хяналтын асуудлууд нь хэр орж ирж байгаа юм.

Хоёрдугаарт, яамнаас яг өнөөгийн байгаа нөхцөл байдалд яам энэ хуулиа хэрэгжүүлэх, зохион байгуулах энэ боломж бололцоо нь хэр байгаа вэ. Түрүүний бас нэг 2 хууль батлаад оруулсан Иргэний нисэхийн тухай хууль, Төмөр замын тухай хуулиуд байгуулагдсан энэ дээр тэгээд дахиад нэг бүтэц, зохион байгуулалт нь болсонгүй гэдэг шалтгаанаар хугацаа сунгаад явчихсан. Энэ дээр тиймэрхүү зүйл гарах уу, үгүй юу. Яамны дотоод үйл ажиллагаатай холбоотой асуудлууд нь зохицуулалт нь яамны бүтэц бүрэлдэхүүнтэй холбоотойгоор зохицож байгаа юу гэдгийг л асуух гээд байна.

Ж.Батжаргал: Хариулт өгье.

Б.Баттөмөр: Яамтай холбоотой асуудлыг бол Болорчулуун сайд сая манай Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаа тэр хуулиуд буцаад байгаа, яам маань органик бүтээгдэхүүний хууль баталсан тохиолдолд энийг хэрэгжүүлээд явах боломж нь юу байна гэж асууж байна. Та хариулсан нь дээр байх. Ер нь органик бүтээгдэхүүний талаар би нэг хэдэн зүйл хэлье гэж бодож байгаа юм. Энд дэлхий нийтээрээ энэ органик бүтээгдэхүүний төлөө явж байгаа л даа. Өнөөдөр бол дэлхийд нийт хүнсний бүтээгдэхүүний 8 орчим хувь нь бол органик гэж үзэж байгаа юм.

Энийг бол цаашдаа тэр нөгөө Тогтвортой хөгжил-2030 гэдэг хөтөлбөрийн хүрээнд 15 хувь болгоно гэж явж байгаа. Бид нар бол нөгөө Алсын хараа-2050 дээрээ бол 2030 онд 5 хувьд оруулна гэж бид оруулсан юм. Би бас тэр алсын хараа 2050-д оролцсон хүний хувьд бол энийг маш тод санаж байгаа. Өнөөдөр энэ нь 0,01 хувиас ч бага байгаа байх. Яг жинхэнэ органик бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа 14 аж ахуйн нэгж байгаа. Маш жижигхэн борлуулалттай. Тэгээд энийг дэмжих шаардлагатай. Энэ яаж байна вэ гэхээр судалгаа байна л даа. Манай Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас гаргасан судалгаа, Эрүүл мэндийн яамнаас гаргасан судалгаагаар хоол боловсруулах, ходоод болон хоол боловсруулах замын өвчлөлийн 76 орчим хувь нь хоол хүнстэй холбоотой байна гэж ингэж гарч байгаа юм. Тийм учраас бол юу гэхээр бид чинь бол янз бүрийн юм хэрэглэж байна шүү дээ. Янз бүрийн бордоогоор бордсон янз бүрийн юм хэрэглэж байгаа учраас Монгол Улс чинь ялангуяа энэ ходоод хоол боловсруулах эрхтний өвчлөлөөр энэ дэлхийд тэргүүлж байгаа шүү дээ. Нас баралтаар ч тэргүүлж байгаа. Тийм учраас энд бол ямар нэгэн тэр татвар аваад байсан юм бол байхгүй. Төсөвт нөлөөлөх юм байхгүй. Төрийн бодлогоор бол энэ органик хүнс гэдгийг бол дэмжих

ёстой. Бүх талаар дэмжих ёстой. Органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа, тарьж байгаа органик мах үйлдвэрлэж байгаа хүнс, ногоо бүх бүтээгдэхүүнийг бүх талаар дэмжих ёстой гэж ийм концевцын үндсэн дээр энэ хууль маань ингээд боловсруулагдсан. Энэ дээр бол бид нар нэлээн зарчмын зөрүүтэй саналуудыг оруулж ирсэн. Ийм л концевцыг энд ажлын хэсэг ажиллаж Байнгын хороонд оруулж ирж байгаа юм. Сайд хариулна.

Ж.Батжаргал: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасныг баримтлан ажлын хэсгээс 3 саналын томъёолол бэлтгэсэн байна. Уг дэгийн тухай хуулийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн бол санал хураалт явуулж болохоор заасан юм байна. Тэгэхээр ажлын хэсгээс бэлтгэсэн 3 зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулахын өмнө энэ бэлтгэсэн 3 саналыг томъёоллоор дахин санал хураалт явуулъя гэдэг томъёоллоор санал хураалт явуулж хуралдаанд оролцож байгаа гишүүдийн 2/3-оос дээш нь дэмжигдсэн тохиолдолд зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явагдахаар ингэж дэгээр зохицуулагдсан юм байна. Тийм учраас ажлын хэсгээс бэлтгэсэн саналын томъёоллуудаар санал хураалт явуулах нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 2/3-аар дэмжигдэх юм байна шүү.

Хуралдаанд оролцсон гишүүдийн 9 хувийн саналаар дахин санал хураалт явуулахыг дэмжсэн байна. Ийм учраас бэлтгэсэн саналын томъёоллуудаар санал хураалт явуулъя.

1.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөлд 2 санал байгаа юм байна.

1.Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.3.Гаалийн байгууллага улсын хилээр нэвтрүүлсэн органик бүтээгдэхүүнтэй холбоотой мэдээллийг мэдээллийн санд илгээнэ.” Ажлын хэсгийн санал байна. Санал хураалт. Хуралдаанд оролцсон гишүүдийн 90 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтын “дотоодод үйлдвэрлэсэн” гэсний дараа “, баталгаажсан, мэдээллийн санд бүртгэлтэй” гэж нэмж, мөн заалтын “ашиглаж байгаа тариалангийн анхан шатны” гэснийг “ашигласан тохиолдолд” гэж өөрчилж, мөн зүйлийн 15.1.2 дахь заалтыг хасах. Санал хураалт. Хуралдаанд оролцсон гишүүдийн 90 хувийн саналаар дэмжигдлээ.

Одоо Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар 1 зарчмын зөрүүтэй санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.5.10¹ заалт нэмсүгэй.

22.5.10¹.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн 4.1.2-т заасан органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн аж ахуйн нэгжийн зөвхөн тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсэн эхний 3 жилд 90 хувиар, дараагийн 3 жилд 50 хувиар гэсэн ийм ажлын хэсэг бэлтгэсэн байсан. Сая Болорчулуун сайд 5, 5-аар явах нь зөв гэснийг ажлын хэсэг дэмжээд манайх яг энэ саналаар нь санал хураалгая гэж оруулж байгаа юм байна. Тийм учраас

эхний 5 жилд 90 хувиар, дараагийн 5 жилд 50 хувиар гэсэн саналын томъёолол болж байна. Мөн биз дээ. Тэгвэл санал хураалт. 80 хувийн саналаар дэмжигдлээ. Би дэмжсэн орсонгүй. Минийхийг тэмдэглэлд дэмжсэнээр аваарай.

Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Ажлын хэсгийнхэн, ажлын дэд хэсгүүддээ баярлалаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан өндөрлөж байна.

16.09 цаг

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ